



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар A/528

Булган сум


Монгол-Япон залуучуудын хөгжлийг дэмжих хамтын үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх ажилд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны IX хуралдааны “Залуусын хөгжил” хөтөлбөр батлах тухай IX/69 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол-Япон залуучуудын хөгжлийг дэмжих хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах залуучуудын клуб байгуулж, сайн дурын ажлыг орон нутагт зохион байгуулсугай.


2. Тус үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 9,700,610 (есөн сая долоон зуун мянга зургаан зуун арав) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Залуучуудын хөгжил, хамгаалал” хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. ПҮРЭВ-ОЧИР

07
А/528
Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 30-ны нийгмийн өдрийн
дугаар захирамжийн хавсралт



МОНГОЛ - ЯПОН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
8 дугаар сарын 02				
1.	Япон улсаас "Good" байгууллагын Монгол улс хариуцсан зохицуулагч, сайн дурын ажилчдыг хүлээн авах	5 хүн	33,600	168,000
2.	Хүндэтгэл үзүүлэх	5 хүн	45,000	225,000
8 дугаар сарын 07- 08 дугаар сарын 15-ны өдрүүд				
1.	Япон улсаас ирэх төлөөлөгч залуусыг угтах ажлын бэлтгэл хангах	-	345,000	345,000
2.	Политехникийн коллежийн дотуур байранд 7 хоног байрлуулах	30 хүн	28,000	840,000*7= 5,880,000
3.	Автобусны тооцоо: - Булган – Эрдэнэт – 70км - Эрдэнэт – Булган - 70км - Булган – Онгоцны буудал – 7км - Онгоцны буудал – Булган – 7км - Булган – Жаргалант – 15км - Жаргалант – Булган – 15км - Булган – Онгоцны буудлын ар – 35км - Онгоцны буудлын ар - Булган – 35км - Булган – Баатарван – 140км - Баатарван – Булган – 140км - Булган доторх холхио – 100км - Булган – Эрдэнэт – 70км - Эрдэнэт – Булган – 70км Нийт – 774км*2=1548км	387л	3030 төгрөг	1,172,610
4.	Жолоочийн хөлс	2	40,000	80,000*7=560,000
5.	Хүндэтгэл үзүүлэх	30	45,000	1,350,000
Нийт - 9,700,610				